



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 19

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хэмнэлтийн тухай хуулийн дагуу татан төвлөрүүлсэн 13 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 202,048,139/хоёр зуун хоёр сая дөчин найман мянга нэг зуун гучин есөн/ төгрөгийн балансын үнэтэй 37,001,388.74 /гучин долоон сая нэг мянга гурван зуун наян найман төгрөг далан дөрвөн мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 14 ширхэг автомашины худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Адьяасүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхэд хяналт тавих;


2.3 Тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн  
19 дүгээр тогтоолын хавсралт



Худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Ахмадын хороо	УАЗ, 29891	ДУА	4204	2006	2018	1,500,000	1,500,000	0.00	1,500,000
2	Биеийн тамир, спортын газар	УАЗ, 220692	ДУА	7955	2013	2013	13,500,000	13,500,000	0.00	1,500,000
3	Музей	УАЗ, 220692	ДУА	6886	2010	2018	10,000,000	10,000,000	0.00	1,500,000
4	Орон нутгийн өмчийн газар	LEXUS, LX470	ДУЭ	0044	2000	2011	20,990,200	20,990,200	0.00	15,000,000
5	Статистикийн хэлтэс	Hyundai, Starex	ДУЭ	0030	2001	2013	6,300,000	6,300,000	0.00	500,000
6	Адаацаг сумын ЗЗТГ	NISSAN, Murano	ДУЭ	2066	2004	2016	10,000,000	10,000,000	0.00	2,000,000
7	Баянжаргалан сумын ЗДТГ	Toyota, Land Cruiser	ДУА	9191	2006	2014	50,000,000	50,000,000	0.00	20,000,000
8	Дэлгэрцогт сумын ЗДТГ	Toyota, Prius	ДУА	6301	2006	2015	9,528,000	9,528,000	0.00	2,000,000
9	Хулд сумын ИТХ	Toyota, Ist	ДУА	1812	2004	2016	10,000,000	10,000,000	0.00	1,500,000
10	Цагаандэлгэр сумын ЗДТГ	Toyota, Land Cruiser	ДУА	3281	2004	2015	50,000,000	25,277,777.96	24,722,222.04	24,700,000
11	Эрдэнэдалай сумын ИТХ	УАЗ, 31512	ДУА	1515	2004	2018	3,500,000	2,858,333.17	641,666.83	2,500,000
12	Эрдэнэдалай сумын ИТХ	Lexus 4.70	ДУА	3227	2004	2011	10,000,000	1,979,166.73	8,020,833.27	15,000,000
13	Эрдэнэдалай сумын	уаз 31512	ДУЭ	1857	2004	2017	3,000,000	3,000,000	0.00	1,500,000

14	ЕБС Эрдэнэдалай сумын соёлын төв	УАЗ, 2206	ДУА	8950	2006	2014	3,729,939	3,729,939	0.00	1,500,000
Нийт							202,048,139 /хоёр зуун хоёр сая дөчин найман мянга нэг зуун гучин есөн/ төгрөг	165,046,750.2 6	37,001,388.74 /гучин долоон сая нэг мянга гурван зуун наян найман төгрөг далан дөрвөн мөнгө/ төгрөг	90,700,000

